

**УГСААТНЫ ЁС ЗҮЙН АСУУДАЛД**

М.ЗОЛЗАЯА

Хэл Иргэншлийн Дээд Сургууль

**Түлхүүр үг:** Этнограф, этнологи, хүн судлал, угсаатны ёс зүй.

Орон зайн өөр өөр алслал бүхий угсаатан бүр өөрийн гэсэн өвөрмөц ёс зүйн хэм хэмжээ, зарчим, сургаалтай байдаг. Эл өгүүлэлд усаатны ёс зүйн судалгааны асуудлыг тоймлон авч үзлээ. Эртний Грекийн "этнос" буюу угсаатан гэдэг үг XVIII-XIX зууны зааг үед судалгааны бүтээлүүдэд тэмдэглэгдэх болжээ. Германы түүхч, хэл шинжээч А.Л.Шлозер "Allgemeine nordische geschichte /1977/" бүтээлдээ "ethnography", "völkerkunde" гэх утга ижил үгсийг анх хэрэглэсэн байна. 1790-ээд онд Герман хэлт эрдэмтдийн дунд дээрх үгс нэгэн зэрэг өргөн хэрэглэгдэж байсан. А.Л.Шлозер энэ үгийн утгыг тайлбарлахдаа "ард түмэн, үндэстний түүхэн төлөв байдлын судалгаа" гэж тодорхойлжээ. Oxford Англи хэлний толь, Penny тайлбар тольд "дээрх үгийг Германы судлаачид хэрэглэдэг бөгөөд Угсаатан зүй гэж орчуулж болно, Graphy нь үзэл санааг таних чадвар гэсэн утгатай" хэмээжээ. **Этнограф** нь олон үндэстэн ястны эд өлөг, хэл, ёс заншил, урлаг, хөгжил дэвшлийн тухай баримтыг системтэй эмхлэн нарийвчилж үзээд соёл ахуйн ялгааг тогтоодог шинжлэх ухааны салбар юм. Үүний зэрэгцээ гэрэл зураг, архивын баримт, дуу бичлэг, ёс заншил, аман зохиол зэрэг эх сурвалжид тулгуурлаж түүхийн үйл явцад шинжилгээ хийх зорилготой. Америкийн академийн тайлбар тольд "угсаатны зүйг орчин үеийн хүн судлалын нэг салбар бөгөөд шууд ажиглалтанд суурилсан аж төрөхүйн тухай судалгаа" гэж томъёолсон байна. Энэ нь хоёр үе шаттай. 1. Тэмдэглэх, ажиглах үйл явц. 2. Судалгаандаа шинжилгээ хийх, хээрийн шинжилгээ хэмээн тодорхойлжээ<sup>1</sup>. XIX зууны дунд үеэс угсаатны тухай шинжлэх ухааныг этнологи, хүний тухай шинжлэх ухааныг хүн судлал гэх болсон буй.

1784 онд А.Шаваном этнологи гэх үгийг хэрэглэсэн. XIX зууны түүхч Ж.Ричард "эртний овог угсааны түүхийг мөшгөж, нийгмийн харилцааг тодорхойлж дүгнэсэн" судалгаагаа этнологи гэж нэрлэжээ<sup>2</sup>. Түүнийг нийгмийн угсаатан судлалыг үндэслэгч хэмээн үздэг. Угсаатан судлалыг хүн судлалтай адилтгах үзэл түгээмэл байсан. Хүн өөрийгөө тодорхойлох шаардлагаар үүссэн философийн нэг салбар нь хүний философи. Хүний философи хүний өөрийн мөн чанараар нь зуучлагч болгодог өвөрмөц

<sup>1</sup> Academic American encyclopedia. USA. 1983 V-7 p.256-257<sup>2</sup> The dictionary of anthropology. Ed. Thomas Barfield. Malden. 2000



онтологитой. Хүн хэм хэмжээнээс хэтэрсэн өөрийн амьтанлаг чанараа хэрхэн удирдаж хязгаарлах вэ гэдэг хүний философи, ёс зүйн чухал асуудал. Угсаатан судлал, хүн судлалын холбоон дээр орчин үед нийгмийн хүн судлал, соёлын хүн судлал шинжлэх ухааны чиглэл зэрэгцэн оршдог. Соёлын хүн судлал нь хүн ба соёлын харилцан холбоог судалдаг. Нийгмийн хүн судлалын судлах зүйл нь орчин үеийн болон уламжлалт нийгэм дэх хүн, нийгмийн амьдралын зохион байгуулалт, амин чухал ертөнц болох хэл, соёл, улс төрийн зохион байгуулалт нэгдэн орших нөхцлүүдийг судална. Дашрамд дурьдахад этнограф, этнологи хэмээх дагаврын ялгаатай үгсийг судлаачид адилхан утгаар хэрэглэсээр байна. Logos дагавар нь судлал, зүй гэсэн утгатай бол Graphy нь бичих гэсэн грек үгнүүд юм. Манай судлаачид ч академич Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв<sup>1</sup> нарын орос монгол тольд этнография-угсаатны зүй, этнология-угсаатан судлал гэж орчуулсныг баримтлаж заншжээ.

Этнологи буюу угсаатан судлал нь янз бүрийн угсаатны бүлгүүдийн хөгжил, бүрэлдэх үйл явц, тэдний адилсал, өөрийгөө зохион байгуулах соёлын хэлбэр, тэдгээр бүлгийн зан байдал, хамтын харилцааг судалдаг шинжлэх ухаан юм<sup>2</sup>. Шинжлэх ухааны тогтолцоонд угсаатан судлалын эзлэх байр эцсийн дүндээ судалгааны үндсэн объектоо угсаатан, угсаатны мөн чанар буюу угсаалаг байдлаар тодорхойлдог. Орчин үеийн угсаатан судлал сонгодог арга зүй, онолын хандлагыг баримталсаар буй боловч олон талын шинэлэг чиглэлээр хөгжиж байна. Тухайлбал угсаа-хэл шинжлэл, угсаатны утга зүй, угсаатны сэтгэл зүй, угсаатны ёс зүй, угсаатны социологи, сурган хүмүүжүүлэх ухаан гэх мэт. Угсаатны ухамсар, оюуны соёлд янз бүрийн өөрчлөлт гарч буй үед судалгааны асуудалд хандахад бусад шинжлэх ухаануудын уулзварт шийдвэрлэх асуудлууд дэвшигдэх боллоо.

Бидний анхаарал татаж буй салбар нь угсаатны ёс зүй юм. Дэлхий ертөнц даяарших явц эрчимжсэн өнөө үед угсаатны ёс зүйн асуудлыг улам бүр нарийсган онолын үүднээс хандаж, түүний эерэг, сөрөг талыг нь олж тогтоох, ёс суртахууны хямралаас гарах арга замыг боловсруулах нь угсаатны хамтын нийгэмлэгийн судалгаанд шилжиж байна. Ийм судалгаа шинжилгээ нь тухайн нэг угсаатны хүрээнд явцуурах байдлаар төсөөлөгдөх биш, бие биенээсээ улам бүр хамааралтай болсон хүмүүн төрөлхтний ёс зүйг нигүүлсэнгүй болгоход чиглэгдэж, үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэх болжээ. Өөрөөр хэлбэл, ёс суртахууны харилцааны угсаалаг шинжийг

<sup>1</sup> Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982

<sup>2</sup> Садохин.А.П. Грушевицкая.Т.Г. Этнология М.,2000



тогтоох зорилготой. Олон улсыг түгшээж байгаа шашин хоорондын мөргөлдөөн, гэмт хэргийн өсөлт, амиа золиослох, тэгш бус байдлын золиос зэрэг ёс суртахууны сөрөг үзэгдэл дэх угсаалаг шинжийг тогтоох хэрэгцээ тулгарч байна. Тиймээс түүхэн хөгжлийн аль нэг үед угсаатныг тодорхойлох ямар шинж давамгайлж байна гэдгээс тухайн угсаатан, нийтлэгийн мөн чанар, түүний бүтээсэн соёлын хувьсал хамааралтайг харгалзах онолын чиглэлүүд бий болжээ<sup>1</sup>. Оросын судлаач В.Ю.Бромлей, Л.Н.Гумилев нар угсаатны нийгэмшил, соёлын асуудлыг судлахын зэрэгцээ угсаатны ёс зүйд ч анхаарлаа хандуулсан байдаг. XIX зууны 40-өөд онд Парисын угсаатан судлалын нийгэмлэгийн дүрэмд угсаатны зүйн хүрээг "хэлний уламжлал, түүх, ёс суртахуун, оюун ухааны чадамж, бие махбодийн бүтэц, хүний арьсны онцлогийг" судална гэж заасан. Орост 1920-иод оноос дорно зүг, хойд Кавказын аж байдал соёлыг судлах явцад тэдний заншлын эрх, ёс зүйг хавсарга байдлаар судалжээ. Хэм хэмжээт угсаатны зүйн /нормативная этнография/ хүрээнд угсаатны хууль эрх, ёс зүйг хам авч үздэг бөгөөд эрхийн, ёс зүйн гэж ангилсан<sup>2</sup>. Энэхүү ангилал нь угсаатны нийгмийн харилцааг түүхэн явцад эхлээд ёс зүй, дараа нь эрх зүй үүсэн зохицуулж ирсэн гэдэгт үндэслэжээ. Ерөнхий онолын эрх зүй, ёс зүйн бие даасан салбарын ойлголт, зарчимд тулгуурлаж тухайн угсаатны ёс суртахууны уламжлалыг нь судалдаг. Угсаатны ёс зүй, эрхийн уламжлал нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй сөхөгддөг. Угсаатны ёс зүй /ethnoethics, этнография морали/ 1970-аад оноос бие даан хөгжиж олон арван судалгааны ажил хийгдэж байна<sup>3</sup>. Тухайлбал Оросын философич Г.Е.Адушкин<sup>4</sup>, Е.Анчел, М.В.Кашуба<sup>5</sup>, Р.Г.Апресян, Коан нар судалгааны туршлага хуримтлуулжээ. Энэ салбарын судлах зүйл нь *тодорхой нэг угсаатны ёс суртахууны ухамсар, харилцаа, үйлдэл: ёс суртахууны хүмүүжил олгодог арга, ёс зүйдээ баримталдаг хэм хэмжээ, үнэлэмж, ёс зүйн утга зохиол, ёс суртахууны уламжлал шинэчлэлийн асуудал* байна. Хүмүүсийн харилцаа, нийгмийн байдал, мэргэжил, бүлгийн соёл, зохион байгуулалт, угсаатны онцлог зэргээс шалтгаалдаг. Тухайн угсаатан, үндэстний нийгмийн харилцааг удирдан чиглүүлэх өөрийн гэсэн өвөрмөц ёс зүйн дүрэм журам бий болсон байдаг. Энэ нь **inter ethnic** соёлыг бүрдүүлэх, өөрөөр хэлбэл угсаатан хоорондын харилцааны эвсэг найрсаг,

<sup>1</sup> Г.Цэрэнханд. Монголчууд: Угсаа-соёл, зан заншил УБ..2005 9-р тал.

<sup>2</sup> Этнография и смежные дисциплины. М.,1988

<sup>3</sup> Dictionary of ethics М.,1990

<sup>4</sup> Нравственные уроки русской классической литературы. М.,1986

<sup>5</sup> Памятники этической мысли на Украине XVII первой половины XVIII ст. Киев.,1987



хүндэтгэлт харилцааг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Угсаатны ёс зүйн хөгжил түүхэн өөрчлөлт, соёлын түвшин, эрх чөлөөт байдал, сүсэг бишрэл, аж төрөх хэв маяг, төрт ёсны үзэл, эв нэгдэлтэй салшгүй холбоотой. Бүх угсаатанд түгээмэл байх ёс суртахууны зарчим, үнэлэмж бий. Бид угсаатны ёс зүйг судлах арга зүйд ёс зүйн ухааны ерөнхий ойлголтуудаас гадна дараах үндсэн ойлголтуудыг зайлшгүй авч үзэх шаардлагтайг тэмдэглэж байна. Үүнд: ёс заншил, ёслол, зан үйл, цээр, үлгэр дууриал, хэв хууль, уламжлал, ёс суртахууны туршлага, эх оронч үзэл. Эдгээр ойлголтуудыг угсаатан судлаачид, соёл судлаачид, философичид янз бүрээр тайлбарлан тодорхойлсон ч энэ удаад хамгийн ерөнхий утгаар авч үзлээ. **Ёс заншил нь** тухайн угсаатны гэр бүлийн, төр, шашны ёсонд уламжилсан өдөр тутмын харилцаанд илэрдэг тогтсон хэв ёс бөгөөд хүнийг нийгэмшүүлэх гол хүчин зүйл юм. Ийм учраас хүн ёс заншлын дагуу биеэ зөв авч явах нь нэг талаас ёс суртахууны хэрэгцээг хангадаг. Ёс заншил ёс уртахууны үйлдлийн бүрэлдэхүүн боловч зарим зан байдлыг зохицуулах боломжгүй болох үе бий. Тухайлбал нийгмийн шилжилтийн үед ёс заншил, ёс суртахууны хувьсал өөрчлөлт явагддаг. Тухайн үеийн нийгмийн давхаргын байдлаар илэрдэг тул хүмүүсийн сэтгэлзүйд нийцэж цаашид хөгжинө. Ёс суртахууны сөрөг үзэгдэл гарах тусам аль ч орны ард түмэн уламжлалт ёс заншлыг хууль дүрмээс ч илүү хүсэмжилдэг нь илт байдаг шинж. Ёс заншлыг төрт хууль ёсны хэм хэмжээлэг үүднээс цэгцэлснийг **хэв хууль** гэнэ. Уламжлалт соёлын хамгийн гол хэсэг нь ёс заншил, тэр нь тухайн угсаатны хэв маяг зан суртахууны чанарыг харуулахыг шаарддаг үйлдэл. Үүгээр хувь хүний зан байдлын хэв шинж тогтдог. Нийгмийн тогтолцоонд тогтвортой үйлчлэх хуульмэт ёс заншлыг барьж явдаг. **Уламжлал** /латины traditio буюу дамжих гэсэн үгнээс гаралтай/ Нийгэмд уламжлал заавал бий. Ёс суртахууны эгэл хэм хэмжээ уламжлалаар баяжигдаж байдаг. Орчин үеийн түүхийн судалгаа дэлхийн угсаатны нийтлэгийн уламжлалыг хуучны гэж үздэг онолчдыг буруушаах болжээ. Өнөөдөр бие биенээсээ ялгаатай угсаатнууд өөрийн өвөрмөц соёлоо хадгалж үлдэхийг эрмэлздэг болсон нь бие биенийхээ уламжлалыг танин мэдэх хэрэгцээний үүднээс нэгдэх, харилцан хүндэтгэх, ойртон дотносох ёс суртахууны эерэг хандлагыг бий болгох юм. Уламжлалт соёлыг рациональ, рациональ биш гэж ангилдаг бөгөөд бэлгэдлийн үнэлэмж, материаллаг хэрэгцээг хангадаг. **Ёс горим /этикет/.** Амьдралд байнга тохиолдож байдаг янз бүрийн нөхцөл байдалд хүн биеэ хэрхэн авч явах дүрэм журмыг ёс



горим гэнэ. Эртний үеэс овгийн жирийн гишүүд ахлагч нартайгаа харилцах харилцааг тэрчлэн нэг овгийн удирдагч өөр овгийнхтой уулзахдаа баримталдаг тодорхой ёс горимууд байжээ. Энэ нь олон нийтийн дунд биеэ эвч явах байдал, хоол зоог хүртэх, харилцан мэндлэх, бие биенээ нэрлэж дуудах, зэрэг олон талтай түүхийн янз бүрийн үед угсаатнуудад өөрчлөгдөн хувьсч байдаг. Ёс горимыг ёс заншил, төр шашны сургаал номлол, цааз хуулиар бататган дэлгэрүүлж ирсэн. **Цээр** /taboo/ бол хүн төрөлхтний нийгэмд түгээмэл оршиж ирсэн соёлын ай бөгөөд үндэстэн бүхний аж амьдрал, шүтлэг бишрэл, хэв суртал, хууль цааз, ёс зүй, гүн ухаан зэрэг өргөн дэлгэр судалгааны цар хүрээтэй холбогдон уламжлал хөгжиж иржээ. Цээрийн ёсгүйгээр хүн харилцааны соёл, нийгмийн ёс зүйг төсөөлөхийн аргагүй. Цээрийн ёсонд шашин шүтлэгийн ухамсраас буй болсон зарим нэг шинжлэх ухааны үндэслэлгүй зүйл байдаг боловч олонхи нь угсаатны амьдрал тэмцлийн туршлагаас олсон сургамж, харилцааны хэрэгцээ шаардлагаар буй болсон хүмүүнлэг сайхан ёс суртахууны илэрхийлэл байна. Ах зах, ёс номоо алдсан хүнийг “цээр цадиг” үгүй хүн гэж муушаадаг. Энэ нь ёс суртахуунгүй, ёсгүй, эмх замбраагүй, эх захгүй гэх мэтийн утгатай. Үүнээс үзвэл “цээр” гэх үг нь ёс журамтай, эх захтай, эмх дэглэмтэй байх гэсэн утга санааг агуулж байдаг. **Ёслол.** Өрнөдийн хүн судлаачид соёлын системийн нэг бүрэлдэхүүн нь ёслол гэж үздэг. Ёслол нь нийгэмд зөвшөөрөгдсөн дүрэм, бэлгэдлийн чанар бүхий уламжлалт төдийгүй орчин үеийн шинжтэй, өвөрмөц дараалалтай үйлдлүүд. Тодорхой утга санааг бэлгэдэн илэрхийлсэн эд юмс, үг яриа, үйл хөдлөл зэрэг хэлбэртэй байж болно. Структуралист хүн судлаачид соёлын итгэл үнэмшлийн мэдрэмж ёслолын үйл ажиллагааны үзэлтэй дотоод логик холбоотой гэж үздэг. **Үлгэр дууриал** гэдэг нь ёс суртахууны хувьд санаачлагатай, бусдыг удирдан чиглүүлдэг, дагаж мөрдөх эрхэм чанар. Энэ чанарыг ер бусын шургуу дайчин, хичээл зүтгэлээр эзэмших тохисолдол бий. Угсаатанд үлгэр дууриал болох ёс зүйн дүрэм журмаас гадна үндэсний бахархал болсон домогт, түүхэн хүн, овог төрөлдөө хүндтэй хүн байдаг. Францын сёол судлаач Клод Леви Стросс “хүний зан төрх илтэд өөр байх боловч тархины бүтэц хийгээд сэтгэн бодох үйл явц ижилхэн байдаг учир ёс суртахуун, сэтгэлзүйн хэв шинжид төсөөтөй талууд илэрдэг” гэжээ. Энэ утгаараа соёлын ялгаа зөрүүг бус адилслаас нь эхэлж судлахыг дэмжсэн байна. Хавсарга хүн судлал нь хүний эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал, хөгжил дэвшилтэй холбогдсон асуудлыг шийдэхэд соёл судлал, археологи, хэл шинжлэл, биологийн судалгааны ажлын дүнд олж авсан мэдлэг, мэдээлэл, дүгнэлтийг



ашигладаг салбар юм. 1950-аад оноос соёл, хүн судлал дотор Sturtevant.W<sup>1</sup>ын үндэслэсэн угсаатан зүйн тодорхойлолтуудыг задлан шинжилж сайжруулахад зориулсан шинэ хөдөлгөөн гарч ирсэн /New ethnography/. Угсаатан судлалын шинжлэх ухаан, хүн судлалын нарийвчилсан судалгааны дүнд угсаатны ёс зүйн салбар үүсэн хөгжиж байна. Хүн төрөлхтний даяаршлын эрин үед угсаатны угсаалаг байдлын адилсал, ондоошлын харилцан уялдаа хамаарлыг судлахдаа ёс суртахууны асуудлыг нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нь бидний өмнө тулгарсан олон ээдрээт асуудлыг шийдвэрлэхэд танин мэдэхүйн болоод практик ач холбогдолтой юм. Янз бүрийн угсаатны ёс зүйн үнэлэмж баримжааллын өвөрмөц байдалд дүн шинжилгээ хийх нь тэдний хөгжил дэвшил, сайн сайхан аьдралын төлөө хамтран ажиллах, ёс зүйтэй хүмүүнлэг ертөнцөд аж төрөх гол хүчин зүйл байх боловуу.

#### Резюме

Данная статья написана обзорные вопросы об этноэтическом методологии. В статье отмечается что, как относиться этика к знанию этнологии. Автор также попытался дать свое определение этического понятия ценности на основе анализ этноэтических вопросов,

#### Ном зүй

1. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ.,1982
2. Г.Цэрэнханд. Монголчууд: Угсаа-соёл, зан заншил. УБ.,2005
3. А.Пунсаг. Монголчуудын цээрийн ёсны хураангуй. УБ.,2003
4. Г.Е.Адушкин. Нравственные уроки русской классической литературы. М.,1980
5. М.В.Кашуба. Памятники этической мысли на Украине XVII первой XVIII половины ст. Киев.,1987
6. Очерки этической мысли в России конца XIX начала XX века. М.,1985
7. Этика и ритуал в традиционном Китае. М.,1988
8. Academic American encyclopedia. USA..1983. V-7
9. Dictionary of ethics. М.,1990
10. The dictionary of anthropology. Ed. Thomas Barfield. Malden.2000
11. Sturtevant.T.W Studies in ethnoscience. USA..1964
12. Этнография и смежные дисциплины. М.,198

<sup>1</sup> Sturtevant.W 1964. "Studies in Ethnoscience"